



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

182 /182/

2021.11.17

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

1919 он.

ТУВШИН ТОГТООХ ҮЗЛЭГТ АМЖИЛТАЙ ШАЛГУУЛЛАА



ЦДБЭЧ, "Соёмбо" редакц, Барилга захиалагчийн алба, Батлан хамгаалах эмгэг судлал, шүүх эмнэлгийн офицер, ахлагч нар түвшин тогтоох үзлэгт хамрагдлаа. Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагч нарын мэргэшил, ур чадвар, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг тогтоож цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилготой тус үзлэг дээрх байгууллагуудад энэ сарын 4-14-ний өдрүүдэд явагдсан бөгөөд өчигдөр шалгалтын комисс нэгдсэн дүнг танилцууллаа.

Энэ үеэр хурандаа Ш.Гантулга үзлэгт үндэслэн бие бүрэлдэхүүний ололттой талыг онцлохын зэрэгцээ

цаашид засаж сайжруулах асуудалд байгууллагын удирдлагууд анхаарч ажиллахыг анхааруулав. Тухайлбал, түвшин тогтоох үзлэг явуулах нөхцөл бололцоог сайтар хангаж, зохион байгуулалтын арга хэмжээг сайн төлөвлөж бэлтгэл ажлыг хангасан, цэргийн алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний хуудас болон хамт олны үнэлгээг бодитой дүгнэсэн гэдгийг онцолсон юм. Нөгөө талаас офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэгийн мөн чанарыг бие бүрэлдэхүүн бүрэн ойлгоогүй, цэргийн биеийн тамирын стандарт, холбогдох журмыг судлах шаардлагатайг ч дурдав.

Мөн ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал "Та бүхний ажил үүргийн онцлогийг маш сайн ойлгож байна. Эрхэлсэн

албандаа үр бүтээлтэй ажиллаж байгааг ч мэднэ. Гэхдээ мөрдөстэй албанд зүтгэж байгаагийнхаа хувьд цэргийн алба, зохион байгуулалт, сахилга хариуцлага, дүрэм журмыг заавал мөрдөх ёстой. Цэргийн алба хаагчдад тавигддаг нийтлэг шаардлага, шалгуурыг та бүхэн хангадаг байх ёстой. Энэ чиглэлд тулхуу анхаарч ажиллаарай. Түүнчлэн нийгэм цаг үетэйгээ ямагт хөл нийлүүлж, өөрчлөлтөд хурдан

дасан зохицож, сэтгэлгээгээ тэлж ажиллах нь чухал шүү. Үүнд ч бас байгууллагын удирдлагууд анхаарч, энэ чиглэлийн сургалтуудад бие бүрэлдэхүүнээ хамруулахад нөхцөл бололцоогоор хангаарай. Дараагийн дугаарт, сэтгэл зүйн бэлтгэлжилтэд хувь хүний хичээл зүтгэлээс шалтгаалах зүйл их" хэмээгээд бие бүрэлдэхүүнд ажлын амжилт хүссэн юм.



АРТИЛЛЕРИЙН ЦЭРГИЙН 100 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги БНМАУ-ын баатар, ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, ЗХУ-ын Маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн бие бүрэлдэхүүн

орчин цагийн артиллерийн цэрэг үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлээ. Баярын хүрээнд ангийн нийт бие бүрэлдэхүүнд "Артиллерийн цэргийн үүсэл, хөгжил,

өнөөгийн байдал" сэдвээр яриа танилцуулга хийв. Мөн ангийн байрлалд артиллерийн зэвсэглэл, багаж хэрэгслээр үзэсгэлэн дэлгэсний дээр артиллерийн холимог батареены нэгдсэн дадлагыг цагийн байдлын

хүндрүүлсэн нөхцөлд, тактик жагсаалын хэлбэрээр зохион байгуулжнийт бие бүрэлдэхүүнд артиллерийн батареены байлдааны ажиллагааг сонирхууллаа. Үүний дараа байнгын бие бүрэлдэхүүний дунд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан "Далд харааны буудлага", гар бөмбөгийн тэмцээн, шинэ дайчдын дунд шатрын тэмцээн, "Миний мэдэх артиллери" сэдэвт шүлгийн уралдааныг зохион байгуулсан юм. Энэ үеэр артиллерийн мэргэжлийн ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлэх, алдар гавьяа, туршлагыг нь сурталчлах ажлын хүрээнд гурван үеийн уулзалтыг зохион байгуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран богино хэмжээний нэвтрүүлэг бэлтгэлээ. Мөн эрхэлсэн ажил албандаа амжилт гаргаж байгаа зарим бүрэлдэхүүнийг ангийн захирагчийн тушаалаар шагнаж урамшууллаа.

Ахмад Э.МӨНХБАЯСАХ

Хятадын талыг баримтлагч, Ерөнхий сайд Шанзудба Бадамдорж тэргүүлэн, засгийн газрын гишүүн, дэд сайд зэрэг 16 ноёд, лам нар автономит засгийг сайн дураараа устгахыг зөвшөөрсөн баталгаа бичиг үйлдэн Сүй Шужанд гардуулжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-2	-17

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,275.0	3,285.0
CNY	445.80	449.80
RUB	38.50	40.00
JPY	24.65	25.23
KRW	2.38	2.46

ЗУРХАЙ

2021.11.17 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 13/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Жаргал ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.00-17.14
Барилдлага:
Үл зохилдох
Шүтэн барилдлага:
Мунхрахуй
Суудал:
Шороо

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хараал, жатхыг буцаах, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 366.111	ЭДГЭРСЭН 536,920	НАС БАРСАН 1,826	+753	+11
-----------------------------	---------------------	---------------------	------	-----

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 6367	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 129	ЭДГЭРСЭН 6115	+108
-------------------------	----------------------------	------------------	------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 255,055,580
Эдгэрсэн Нийт: 230,571,907
Нас барсан Нийт: 5,129,190

"Эх оронч залуу" үндэсний хөтөлбөрийн хүрээнд...

"ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХОВД АЙМАГТ ҮРГЭЛЖЛЭВ



Зэвсэгт хүчний 123 дугаар анги

Зэвсэгт хүчний Жанжин штаб, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран улс орон даяар зохион байгуулж байгаа "Эх оронч залуу" үндэсний хөтөлбөр Ховд аймагт буухиалан үргэлжилж байна. Тус аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдад "Эх оронч гэж

юу вэ" сэдвийн хүрээнд эх орноо хэрхэн хайрлах тухай яриа өрнүүлж, харилцан ярилцлаа.

Ялангуяа, сургалт зохион байгуулагчид "Цэрэг гэдэг өөрөө эх орон юм шүү" хэмээн тодотгож, дайчдыг албаа нэр төртэй хаахыг зааж байсан юм. Энэхүү сургалт нь хугацаат албаны дайчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх, бие даан амьдрах чадвар, нийгмийн хариуцлагыг нь дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ

болж чадлаа.

Мөн Зэвсэгт хүчний 123 дугаар ангиас хугацаат цэргийн алба хаагчдад үндэсний түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд хууль, эрх зүйн мэдлэг олгоход анхааран ажиллаж байна. Энэ хүрээнд "Их эзэн Чингис хааны баатарлаг түүхэн замнал" сэдэвт ярилцлага, "Аймаг бүхэн сайхан" өдөрлөг зохион байгуулж, дайчид өөрийн орон нутгийн байгалийн өвөрмөц тогтоц, домог, түүхийн талаар харилцан мэдээлэл солилцсон юм. Мөн Ховд аймгийн Цагдаагийн газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах мэргэжилтэн, хошууч Т.Оронбасар "Зөрчлийн тухай" болон "Цэргийн алба хаагчдын эрх зүйн байдлын тухай" хуулийн талаар хугацаат цэргийн алба хаагчдад яриа таниулга хийж, дээрх хууль тогтоомжийн хүрээнд танин мэдэхүйн хөгжөөнт "Чанга шивнээ"-г зохион явууллаа. Төгсгөлд нь "Түргэн хэллэг хэн сайн хэлэх вэ?", "5000 инээд", "Та битгий уурлаарай" хөгжөөнт тэмцээнүүдийг зохиож, дайчдынхаа хамт олонч уур амьсгалыг бүрдүүлж ажиллалаа.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ

"ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" СУРГАЛТ БОЛОН "СОЁЛ ТҮГЭЭЭ" АЯНЫ ХҮРЭЭНД УРЛАГИЙН ТОГЛОЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх, тэдний соёл боловсрол, бие даан амьдрах чадвар, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилготой "Эх оронч залуу" сургалт нөлөөллийн арга хэмжээ Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн соёлын төвд зохион байгуулагдлаа.

Сургалтыг Залуучуудын ордны арга зүйч О.Тунгалаг, урлагийн тоглолтыг "Хүүхэд залуучуудын Соёлын төв"-ийн дарга, СТА Ч.Болдоо нар удирдан явууллаа. Сургалтад ангийн 200



гаруй хугацаат цэргийн алба хаагч хамрагдсан бөгөөд арга хэмжээг Орхон аймгийн Баян-Өндөр сумын "EBS" TV-ээр сурталчилсан юм.

"ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРӨӨР...



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Зэвсэгт хүчний Жанжин штаб, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж байгаа

"Эх оронч залуу" үндэсний хөтөлбөрийн хүрээнд цөөнгүй ажил, арга хэмжээг зохион байгуулсаар байна.

Өмнөговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдад "Эх орон гэж юу вэ?", "Эр цэргийн сэтгэл зүй" сэдвийн хүрээнд эх орноо хэрхэн хайрлах тухай яриа өрнүүлж, харилцан ярилцлаа.

Мөн сэтгэл зүйн ганцаарчилсан уулзалтыг хийж, шаардлагатай дайчдад зөвлөгөө, мэдээллийг өгч, хөгжилтэй тэмцээнүүдийг зохион байгуулан, гарын бэлэг гардуулан өгсөн юм.

Дэслэгч Б.БАТЗАЯА

"ЭХ ОРОНЧ ЗАЛУУ" ҮНДЭСНИЙ АЯН ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ...



Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Зэвсэгт хүчний Жанжин штаб, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, "Эерэг тэмүүлэл" ТББ-тай хамтран улс орон даяар зохион

байгуулж байгаа "Эх оронч залуу" үндэсний хөтөлбөр Өвөрхангай аймагт амжилттай үргэлжилж байна.

Өвөрхангай аймгийн Хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн

зөвлөлийн тэргүүн Б.Ууганхүү Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн нийт бие бүрэлдэхүүнд "Эх оронч үзэл" сэдвээр лекц уншиж, харилцан ярилцлаа. Тэрээр эх оронч үзлийг хамгийн ихээр түгээн дэлгэрүүлэгч, гүйцэтгэгч нь цэргийн алба хаагчид байдгийг онцлоод хугацаат цэргийн албаа хаахаар ирсэн дайчдыг "Та бүхэн харьцангуй цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлээр төлөвшсөн залуус байна. Яагаад гэхээр цэргийн алба өөрөө эх орончдын цугладаг газар" хэмээн тэднээр бахархаж буйгаа хэллээ.

Тус арга хэмжээний үеэр аймгийн "Соёмбо" телевизийн уран бүтээлчид "Эх оронч үзэл" сэдвээр нэвтрүүлэг бэлтгэн, орон нутгийн иргэдэд түгээхээр ажилласан юм.

Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН

ШИНЭ ДАЙЧИД 10 КИЛОМЕТРИЙН МАРШ ҮЙЛДЛЭЭ



Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Зэвсэгт хүчний Жанжин штаб, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран улс орон даяар зохион байгуулж байгаа "Эх оронч залуу" үндэсний хөтөлбөр Ховд аймагт буухиалан үргэлжилж байна. Тус аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдад "Эх оронч гэж юу вэ" сэдвийн хүрээнд эх орноо хэрхэн хайрлах тухай яриа өрнүүлж, харилцан ярилцлаа. Ялангуяа, сургалт зохион байгуулагчид "Цэрэг гэдэг өөрөө эх орон юм шүү" хэмээн тодотгож, дайчдыг албаа нэр төртэй хаахыг зааж байсан юм. Энэхүү сургалт нь хугацаат албаны дайчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх, бие даан амьдрах чадвар, нийгмийн хариуцлагыг нь дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болж чадлаа.

Мөн Зэвсэгт хүчний 326 дугаар ангиас хугацаат цэргийн алба хаагчдад үндэсний түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд хууль, эрх зүйн мэдлэг олгоход анхааран ажиллаж байна. Энэ хүрээнд "Их эзэн Чингис хааны баатарлаг түүхэн замнал" сэдэвт ярилцлага, "Аймаг бүхэн сайхан" өдөрлөг зохион байгуулж, дайчид өөрийн орон нутгийн байгалийн өвөрмөц тогтоц, домог, түүхийн талаар харилцан мэдээлэл солилцсон юм. Мөн Ховд аймгийн Цагдаагийн газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах мэргэжилтэн, хошууч Т.Оронбасар "Зөрчлийн тухай" болон "Цэргийн алба хаагчдын эрх зүйн байдлын тухай" хуулийн талаар хугацаат цэргийн алба хаагчдад яриа таниулга хийж, дээрх хууль тогтоомжийн хүрээнд танин мэдэхүйн хөгжөөнт "Чанга шивнээ"-г зохион явууллаа. Төгсгөлд нь "Түргэн хэллэг хэн сайн хэлэх вэ?", "5000 инээд", "Та битгий уурлаарай" хөгжөөнт тэмцээнүүдийг зохиож, дайчдынхаа хамт олонч уур амьсгалыг бүрдүүлж ажиллалаа.

Мөн Зэвсэгт хүчний 326 дугаар ангиас хугацаат цэргийн алба хаагчдад үндэсний түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд хууль, эрх зүйн мэдлэг олгоход анхааран ажиллаж байна. Энэ хүрээнд "Их эзэн Чингис хааны баатарлаг түүхэн замнал" сэдэвт ярилцлага, "Аймаг бүхэн сайхан" өдөрлөг зохион байгуулж, дайчид өөрийн орон нутгийн байгалийн өвөрмөц тогтоц, домог, түүхийн талаар харилцан мэдээлэл солилцсон юм. Мөн Ховд аймгийн Цагдаагийн газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах мэргэжилтэн, хошууч Т.Оронбасар "Зөрчлийн тухай" болон "Цэргийн алба хаагчдын эрх зүйн байдлын тухай" хуулийн талаар хугацаат цэргийн алба хаагчдад яриа таниулга хийж, дээрх хууль тогтоомжийн хүрээнд танин мэдэхүйн хөгжөөнт "Чанга шивнээ"-г зохион явууллаа. Төгсгөлд нь "Түргэн хэллэг хэн сайн хэлэх вэ?", "5000 инээд", "Та битгий уурлаарай" хөгжөөнт тэмцээнүүдийг зохиож, дайчдынхаа хамт олонч уур амьсгалыг бүрдүүлж ажиллалаа.

Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР

Таны сонорт

АЖЛЫН БАЙРНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

ЗЭВСЭГТ ХҮЧИНД ОФИЦЕРЫН АЛБА ХААХ ХҮСЭЛ СОНИРХОЛТОЙ СЭТГЭЛ ЗҮЙЧ МЭРГЭЖИЛТЭЙ ЗАЛУУСЫГ АЖЛЫН БАЙРНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- ЗЭВСЭГТ ХҮЧИНД МЭРГЭЖЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ ХҮСЭЛ СОНИРХОЛТОЙ
- 30 ХҮРТЭЛХ НАСТАЙ БАЙХ

•"СЭТГЭЛ ЗҮЙЧ", "СЭТГЭЛ СУДЛААЧ" ХӨТӨЛБӨРӨӨР ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГССӨН, БАКАЛАВРЫН БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГТЭЙ БАЙХ

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Өргөдөл
- Цагдаагийн байгууллагын тодорхойлолт /ял, шийтгэлгүй тухай/;
- Боловсролын диплом, мэргэшүүлэх сургалтын гэрчилгээний хуулбар

ДАВУУ ТАЛ

- Офицерын албан тушаалд төрийн тусгай алба хаах;
- Тогтвортой ажлын байраар хангагдаж, хөгжиж дэвших;
- Гадаадын оронд мэргэжлийн сургалтад хамрагдаж мэргэших;
- Энхийг дэмжих ажиллагаанд оролцож, үүрэг гүйцэтгэх.

дэлгэрэнгүй мэдээллийг

80023008,89119507

"Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийг Үндэсний батлан хамгаалахын их сургуульд "Цэргийн сэтгэл зүйч" бэлтгэх 3 сарын мэргэшүүлэх сургалтад хамруулж, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангид офицерын албан тушаалд томилон ажиллуулна.